



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/226

Номгон

Эзэмшил газрын зөрчил арилгах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоолын 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Т.Болдын худалдаа, үйлчилгээний зориулалттай 15.84 м2 газрын талбайн хэмжээ зөрүүтэй байгаа тул зөрчлийг арилган илүү эзэмшиж буй 3.16 м2 газрын үнийг төлүүлэн, нэмж эзэмшүүлж хавсралтаар баталсугай


2.Газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн “Э” дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхыг иргэн Т.Болдод үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Газар эзэмших эрх олгох тухай” 52 дугаар захирамжийн хавсралтын 7 дахь хэсгийн иргэн Т.Болдын талбайн хэмжээ хэсгийг хүчингүй болгосугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

1210565

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 29-ний  
өдрийн А/286 дугаар захирамжийн хавсралт



ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ТАЛБАЙН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДӨЖ  
БАЙГАА ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Д/д	Газар эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Хаяг	Талбайн хэмжээ /м2/	Залруулгаар нэмэгдэж байгаа талбайн хэмжээ /м2/	Нийт талбайн хэмжээ
1	Т.Болд	ВЭ60032775	6409000541	Худалдаа нийтийн үйлчилгээний газар, төв цогцолбор	Баянхонгор сум, Номгон 1-р баг, Худалдааны гудамж-3, 331а тоот	15.84 м2	3.16 м2	19 м2